



ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

НЭГ. ЗОРИЛГО:

Эдийн засгийн чиглэлээр сурч буй оюутан, судлаачдын судалгаа хийх чадварыг хөхүүлэн дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлж, олон нийтийн эдийн засгийн бодлогын талаарх ойлголтыг дээшлүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. СЭДВИЙН ЧИГЛЭЛ:

1. Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн сэдвийн чиглэл:

- Мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө
- Инфляци ба эдийн засгийн өсөлт
- Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ
- Инфляцийн бүтцэд гарч буй өөрчлөлт, түүний тогтвортой эсэхийг шинжлэх
- Нийлүүлэлтийн шоктой үе дэхь мөнгөний бодлого
- Хэрэглээний болон хөрөнгийн үнийн өсөлтийн санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөө
- Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт түвшнийг шинжлэх нь
- Үйлдвэрлэлийн зөрүүг тооцох олон хувьсагчийн аргачлал, бусад аргуудтай харьцуулах нь
- Гадаад худалдааны үр ашгийг нэмэгдүүлэх арга хэрэгслүүд
- Валютын ханш ба ГШХО
- Валютын ханшийн хэлбэлзлийн дотоодын аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх нөлөө
- Гадаад өрийн макро эдийн засагт үзүүлэх нөлөө
- Гадаад секторын эрсдэл, тогтворгүй байдал
- Банкуудын зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс
- Банкны өөрийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах нь
- Иргэдийн санхүүгийн боловсрол эдийн засагт нөлөөлөх нь
- Бусад ...

2. Судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлийн сэдвийн чиглэл:

- Төрийн эдийн засаг дахь оролцоо
- Макро эдийн засгийн бодлогын үр дүнг үнэлэх
- Инфляци ба эдийн засгийн тогтвортой өсөлт
- Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах

- Санхүүгийн зах зээлийн хөгжлийг хэмжих нь
- Санхүүгийн болон бодит секторын макро харилцан хамаарал
- Хөрөнгийн урсгалын эдийн засагт үзүүлэх нөлөө
- Сөрөг хүүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх нь
- Засгийн газрын өрийн удирдлага
- Хөрөнгийн үнийн өсөлт ба мөнгөний бодлого
- Засгийн газрын үнэт цаасны зах зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөө
- Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга замууд
- Валютын ханш ба гадаад худалдааны бодлого
- Уул уурхайн салбарын макро эдийн засагт үзүүлэх нөлөө
- Гадаад худалдааны үр ашгийг нэмэгдүүлэх арга замууд
- Экспортыг дэмжих бодлогын олон улсын туршлага
- Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх
- Бусад...

ГУРАВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Онол, аргазүйн үндэслэлтэй
- Шинэлэг, оновчтой санал, санаачлагыг дэвшүүлсэн
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан
- Эконометрик, статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, үр дүнд хүрсэн байх
- Судалгааны ажлаа бичгийн А4 цаасан дээр бичих бөгөөд дээд тал нь 15 хуудсанд багтсан байх
- Судалгааны ажлын бичгийн стандарт:
 - Үсгийн фонд – Times New Roman
 - Үсгийн хэмжээ- 11
 - Мөр хоорондын зай – 1,5
 - Margins – top 2 cm; bottom 2 cm; left 3 cm; right 1.5 cm
- Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утас, и-мэйл хаяг, сургуулийн нэр, курс, мэргэжил, бүтээлийн нэрийг бичих
- Илтгэл нь гарчиг, агуулга, оршил, дүгнэлт ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх

ДӨРӨВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- **1-р шат** Зохион байгуулах комисс илтгэлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг уншиж, ангилал тус бүрээс 5 илтгэлийг эцсийн шатны шалгаруулалтад оруулна.
- **2-р шат** Эхний шатнаас шалгарсан илтгэлүүдийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 10.00 цагт Монголбанкны В байрны 5 давхрын хурлын зааланд хэлэлцүүлнэ.

ТАВ. ШАГНАЛЫН САН

I. Оюутны ангилал

- 1-р байр - Өргөмжлөл, 700 000 /Долоон зуун мянган төгрөг/
- 2-р байр - Өргөмжлөл, 500 000 /Таван зуун мянган төгрөг/
- 3-р байр - Өргөмжлөл, 300 000 /Гурван зуун мянган төгрөг/

II. Судлаачдын ангилал

- 1-р байр - Өргөмжлөл, 1500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/
- 2-р байр - Өргөмжлөл, 1200 000 /Нэг сая хоёр зуун мянган төгрөг/
- 3-р байр - Өргөмжлөл, 900 000 /Есөн зуун мянган төгрөг/

ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ:

- **Хугацаа:** 2016 оны 05 дүгээр сарын 2-ны өдрийн 18.00 цаг хүртэл бүтээлийн хэвлэмэл 2 хувийг Монголбанкны бичиг хэрэгт болон электрон хэлбэрээр communication@mongolbank.mn хаягаар хүлээн авна.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр
Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв**

МОНГОЛБАНК

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolbank.mn веб хуудаснаас болон (976) 11-310081 утсаар лавлана уу.